



Бодол эргэцүүлэл, санал

МИНИЙ МЭДЭХ БАЙЦААН ӨНГӨРҮҮЛЭХ

Улсын хилийн шалган нэвтрүүлэх албаны үүсэл хөгжлийн олон зуун жилийн үүх түүхийг үл өгүүлэн зөвхөн өөрийн мэдэх, олны нэрлэж заншсан "Сүхбаатарын Байцаан өнгөрүүлэхийн" өнгөрсөн, эдүгээгийн талаар эргэн дурсаж санал бодлоо товч илэрхийлэх гэсэн юм. Бүүр 1925 /35/ оны 8 дугаар сард БНМАУ-ын Ардын СнЗ-ийн 24 дүгээр тогтоол гарч гадаадын харьяат нарыг тус улсын хил хязгаарт хэрхэн нэвтрүүлэх тухай заавар баталж энэ ажлыг зөвхөн хил хязгаарын боомтын байцаан өнгөрүүлэх газруудаас зориуд эрхлэн гүйцэтгэхийг зааж нарийн журам тогтоож өгсөн байдаг.

Энэ журмын үндсэн санаа нь улам баяжин боловсронгуй болсоор өнөөг хүрч ирсэн байх юм.

Сэлэнгийн чиглэлээр автомашины болон усан замын тээврээр зорчигч, ачаа нэвтрэх нь жилээс жилд өсөн нэмэгдэж хилийн хамгийн онцгой боомт болсонтой уялдан тус байцаан өнгөрүүлэх нь 1933 онд Алтанбулагт гал голомтоо бадрааж улмаар 1930-аад оны сүүлчээр Цагаан эрэгт суурьшсанаар олонд Сүхбаатарын Байцаан Өнгөрүүлэх гэж нэрлэгдэн өнөөгийн шалган нэвтрүүлэх хилийн хороо болтлоо хөгжиж иржээ.

Түүхийн зарим баримт өгүүлэхийн тулд одоогоос 50 жилийн өмнө Байцаан Өнгөрүүлэхийн даргын тайлан мэдээний нэгэн шарласан хуудсыг сонирхъя.

1950 оны 3 дугаар улиралд ЗХУ-аас 2275 орос, 300 монгол, 1 хятад хүн, Монголоос 2915 орос, 236 монгол хүн, 30586 үхэр, 251, 593 хонь, 11373 ямаа, 1951 оны 3 дугаар улирлын байдлаар ЗХУ-аас 39548 тн мод, 31900 тн чулуун нүүрс, 49466 тн төрөл бүрийн бараа, 23341 тн бензин, 504 автомашин, 4374 тн тоосго, 2660 тн машины масло Монголд орж ирсэн байхад Монголоос 780 тн хүнсний масло, 2687 тн ноос, 18331 тн бензин, 182600 тн өвс ЗХУ-д гарч байсан. Эдгээрийг автомашин, галт тэрэг, усан параходоор тээвэрлэснийг байцаан өнгөрүүлэхийн хилчид хянан шалгажээ.

Цаашид Монгол улсын нэр хүнд, гадаад харилцаа өргөжихийн хэрээр Байцаан Өнгөрүүлэхийн шалгалтын албаны хүрээ далайц нэмэгдэж ирсэн бас нэгэн баримт дурдъя.

1949 оноос Наушки-Улаанбаатар, 1950-иад оны сүүлчээс эхлэн Москва-Улаанбаатар-Бээжингийн олон улсын хурдан галт тэрэг, Улаанбаатар-Эрхүү, Улаанбаатар-Москвагийн харилцааны өөрийн замын галт тэрэг тус тус аялах болсон.

1973 онд зөвхөн төмөр замаар 203986 зорчигч, 135889 тээврийн хэрэгсэл нэвтэрч байсан бол 1982 онд 292125 зорчигч, 213600 тээврийн хэрэгсэл шалган нэвтрүүлж байжээ.

1984 оныг 1974 онтой харьцуулан харахад зорчигчид 69 %, тээврийн хэрэгсэл 78%-иар нэмэгдэн, 1980-аад оны сүүлч гэхэд дэлхийн 70-аад орноос хагас сая шахам хүн зорчин өнгөрсөн байв.

Зорчигчдын зонхилох хувь нь тэр үеийн социалист орнуудын их, дээд сургууль, техник мэргэжлийн сургуулиудад Монголоос суралцагсад, тэдгээр орнуудаас манай орны социалист бүтээн байгуулалтад оролцож байсан мэргэжилтэн, гэр бүлийн гишүүд, Монголд байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн албан хаагчид тэдний гэр бүлийнхэн байсан юм.

Үе үеийн нүсэр хөдөлгөөн Сүхбаатарын Байцаан Өнгөрүүлэхийн удирдлага зохион байгуулалт, хүч хэрэгслийн боломж, хүчин чадлын томоохон шалгуур болж, Байцаан өнгөрүүлэхийн ажилтнууд /офицер, хилчид/ бие сэтгэлийн асар өндөр тэсвэр тэвчээр гарган ажилладаг байлаа. 1990-ээд он хүртэл Байцаан Өнгөрүүлэх нь Монгол улсын хойд хилийн цэг Монгол Шарын даваанаас Хэнтий нутгийн зах Цахар-Минжийн гол хүртэл өргөн уудам хилийн хэсгийг давхар хариуцан хилийн дэглэм, журмыг сахиулан хилийн 14 гарцаар шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулан гүйцэтгэж байсан билээ. Ийм нөхцөлд хилчид үндсэн үүргийнхээ зэрэгцээ гаалийн үүргийг гүйцэтгэж ёстой л "Буяныг гаргахгүй, бузрыг оруулахгүй"-н төлөө ажиллаж байсан юм. Эдүгээ ч гэсэн эдийн засгийн хяналт орхигдоогүй яваа.

Дээр нуршсан баримт бүхэн түүх болон үлдсэн хэдий ч "өнгөрсөн түүхээ мэдэхгүй бол өнөө үеэ бүрэн мэдэхгүй, өнөөгөө бүрэн эс мэдрэвээс ирээдүйгээ харж чадахгүй" амьдрал нотолж, шинжлэх ухаан баталсан байдгийг өгүүлж буй хэрэг.

Нэгэн шинэ мянгантай золгосон өнөө үед ШНА-ны үүрэг роль, ажлын арга тактик улам боловсронгуй, нарийн байхыг шаардсаар байгаа нь мэдрэгдэж байгаа байхаа. Ер нь олон улсын болон өөрийн орны дотоод улс төр, эдийн засаг, эрүүгийн нөхцөл байдлын өөрчлөлт хамгийн түрүүнд улсын хилийн шалган нэвтрүүлэх албанд мэдрэгддэг нь амьдрал практикаар нотлогдсон зүйл гэж би боддог юм.

Хүн төрөлхтний түгээмэл зүй тогтлын дагуу 1990-ээд оны

үеэс олон улсын хэмжээнд ардчилал, өөрчлөн байгуулалтын үйл явц өрнөн, хөрш ЗХУ болон социалист систем задарсанаас манай орон гуравдагч ертөнц буюу хөрөнгөтөн гэгдэж байсан орнуудтай шууд харилцаж, өмнөд хөрштэйгөө харилцах харилцаанд эргэлт гарсан зэргээс үүдэн дэлхийн бүх өнцөг булангаас янз бүрийн үзэл бодолтой хүмүүс, "ганзагын наймаачид" гэсэн шинэ нэр хаягтай хүмүүсийн цуваа тасралтгүй холхиж эхэлсэний ихэнх нь Монголын төмөр замаар зорчих болсон нь Сүхбаатар хот дахь ШНА-ны бие бүрэлдэхүүний үүрэг хариуцлагыг улам өндөржүүлэхийг шаардсан байна.

Зах зээлийн харилцаа улам гүнзгийрч зорчин өнгөрөгчдийн зорилго чиглэлд өөрчлөлт орж улсын хилийг хууль бусаар нэвтрэхийг оролдогчид олширч зөрчлийн төрөл, арга нарийссан байна.

1993 онд хил нэвтрэх эрхийн бичиг баримтын зөрчил өмнөх оныхоос 9.3 % өсөж, 1994 онд 77 орны 630000 мянга гаруй зорчигч, үйлчлэх ажилчдыг шалган нэвтрүүлж, гадаадаас улсын хил зөрчсөн 4 удаагийн, дотоодоос хил зөрчихийг оролдсон 50 гаруй этгээдийг мөн хил нэвтрэх эрхийн бичиг баримтын зөрчилтэй 1536 хүнийг байцаан өнгөрүүлэхийн шалгагч нар илрүүлэн шийдвэрлэжээ.

1996 оны эхний 9 дүгээр сард улсын хил зөрчсөн болон зөрчихийг оролдсон 40 шахам хүн, эрүүгийн гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж байсан 18 этгээдийг илрүүлж, Монгол Улсын визгүй ирсэн гадаадын 163 иргэнд виз олгосон байна.

Улсын хилээр гаргахыг хориглосон 31 удаагийн оролдлогыг илрүүлж 7 сая гаруй төгрөгийн үнэ бүхий эд агуурсыг хурааж улсын зохих санд оруулжээ. Эдгээр олон тоо баримтын ард Байцаан өнгөрүүлэхийн удирдлага, шалгагч, хилчдийн ариун шударга хөдөлмөр байгааг хайхрахгүй байж болохгүй буй заа.

Байцаан өнгөрүүлэхийн шалгагчдын онцлог нь тэд тив дэлхийн өнцөг булан бүрээс зорчин явж байгаа хүн бүхэнтэй хамгийн түрүүнд нүүр учран Монгол хүмүүний ёс жаяг, авир араншин, шинж төрхийг илтгэн таниулдаг биет сурталчилгаа болдог бөгөөд олон түмний хараа хяналтад байдаг хүмүүс юм.

Ийм учраас тэдгээрийн хүмүүжил мэдлэг, зан харьцаа, хэлний соёл, гадаад үзэмж, сонор сэрэмж, хариуцлага, бие бялдар зүс царай бүх талаар сайн байх ёстой гэдэг шаардлага тавигддаг нь ёс төдий зүйл бус улс эх орны эрх ашгаас урган гарч, эцсийн эцэст албаны үр дүн шалтгаалдаг юм. Энэ талаар хувь хүний өөрийн зүтгэл санаачлагаас нэлээд нь шалтгаалах хэдий ч төр засаг, удирдлагын анхаарал халамж шийдвэрлэх нөлөөтэй.

Энэ талаар дэс дараатай олон чухал арга хэмжээ авч ирсний

нэг нь 1960-аад оноос ШНА-ны мэргэжлээр. ЗХУ-д сургасан үндэсний боловсон хүчнээр хангах талаар анхаарал халамж тавьсны ачаар эдүгээ мэргэжлийн удирдлагын түвшинд хүрсэн нь ШНА-ны үр дүнд асар их хүчин зүйл болж иржээ.

Монгол Улсын Үндсэн хуулинд "Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдал, улсын батлан хамгаалах арга хэмжээний салшгүй хэсэг мөн" гэж заажээ. Ийм учраас хил хамгаалалтын албаны нэг үндсэн төрөл болсон ШНА-нд анхаарал тавихгүй байхын аргагүй.

Миний бодлоор улсын хилийн шалга нэвтрүүлэх алба нь туурга тусгаар Монгол Улсын хилийн хаалгаар зорчин өнгөрөгсдийг олон улсын гэрээ хэлэлцээр, хууль дүрмийн тогтоосон журмын дагуу шалган нэвтрүүлж, олон улсын харилцаан дахь хүний эрхийн хэм хэмжээг улсын хил дээр хүндэтгэн сахиулж байгаа Хилийн Цэргийн тусгай мэргэжлийн нэгэн төрлийн хүндтэй алба юм.

Албаа гүйцэтгэхдээ Монгол Улсаас бусад улс оронтой визийн асуудлаар байгуулсан гэрээ хэлэлцээрүүд, дипломат алба, эрх ямбын тухай Венийн конвенц, ОХУ-тай хилийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай гэрээ, Монгол Улсын Хилийн тухай хууль, Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль зэргийг удирдлага болгож байдаг. Энэ ч утгаараа төрийн ивээлд байж улам бүр боловсронгуй, хөнгөн шуурхай болж байх ёстой юм. Сүүлийн жилүүдэд зорчигчдын эрхийн бичиг баримтыг шууд галт тэргэн дотор нь шалгаж шийдвэрлэдэг, гадаадын иргэнд виз олгодог болсон зэрэг нь дээрх шаардлагыг хангахад чухал алхам болж байна.

Цаашид анхаарах зарим зүйлийн талаар ийм саналтай байна. Юуны өмнө хилийн цэргийг Монгол Улсын хууль тогтоох төрийн дээд байгууллагад хилчдийн санал сэтгэлийг шууд илэрхийлж байх боломж олгохын тулд Улсын Их Хуралд төлөөлөлтэй болгох, ШНА-ны цагийн байдал тогтворгүй, мэдээлэл гэнэтийн шинжтэй, өргөн хүрээтэй болсон, хилийн зөрчил үйлдэхийг санаархагчдын арга заль улам бүр нарийн болсон өнөөгийн нөхцөлд ШНА-ны хяналт шалгалтын техник хэрэгсэл хэтэрхий хуучирч, хоцрогдсон тул шалгагч нарын харилцааны хөдөлгөөнт холбоо дохиолол, дуран, бичиг баримтын хуурмаглалыг богино хугацаанд илрүүлж чадах хэрэгслээр хангах, түүгээр ч барахгүй телевизийн системийг хилийн шалгалтын хяналтад ашиглах боломжийг эрж хайх, төсөв төлөвлөгөөнд тусгаж шийдвэрлэх нь чухал байна.

Эдийн засгийн хямрал, үнийн өсөлт, амьжиргааны түвшин ажил албанд шууд нөлөөлөх болсон өнөө үед ШНА-ны хилчдийн ахуй хангалт үйлчилгээнд онцгой анхаарч байх, ихэнхдээ төсвийн гадуур орлогогүй эдгээр хүмүүсийн мөнгөн хангамж аль болох шат

дамжлагагүйгээр шууд, тогтоосон цаг хугацаандаа бүрэн гүйцэд хийгддэг байх нь чухал.

"Амьдрал мөнгөн дээр тогтдог" гэдэг үг дэмий шог яриа бус амьдралын бодит үнэнд ойртсоныг бас л бодууштай. Ялангуяа санхүүгийн хангалт холдох талруугаа хэвийж гүйцэд ирэхгүй болсон нь ШНА-ны тэргүүн фронтынхны санал сэтгэлд нөлөөлөхгүй гэх аргагүй юм. "Цэргийн санал сэтгэл ходоодоороо дамждаг" гэдэг ч эртний хоцрогдсон гээгдмэл санаа биш бололтой.

Байцаан өнгөрүүлэхийн ажилтнуудын орон сууцны хангамж дутагдалтай хэвээр байна. 1959 онд БНМАУ-ын СнЗ-ийн 21 дүгээр тогтоолоор хилийн байцаан өнгөрүүлэхийн ажилтнуудыг төмөр замын байгууллага өөрийн ажилчдынхаа адилаар орон сууцаар хангахаар заасан нь хагас дутуу хэрэгжиж ирсэн хэдий ч он жилүүдийн уртад бараг үдээсэнд орж, зах зээлийн давалгаанд өртөн үндсэндээ хүчингүй болгоход хүрсэн бололтой юм.

Иймд өөрийн гэсэн орон сууцаар хангах төсөв хөрөнгийн асуудлыг дээрээсээ бодолцож өгөхөд илүүдэхгүй санагдана.

Бие сэтгэлээрээ улсын хилийн хамгаалалт, шалган нэвтрүүлэх албанд зүтгэж эдүгээ чөлөөнд гарсан ахмадууд бид алба хашиж явсан анги байгууллагаа түшиглэн тэднийхээ боломжийн хэрээр үзүүлсэн анхаарал халамжид талархаж явдаг билээ. Гэлээ ч жил ирэх тусам асрамж хүсэмжлэх нь нэмэгдэж байдаг ахмадууддаа ядарсан үед нь нэмэгдэл тэтгэлэг, тусламж үзүүлэх, эмчилж сувилах зэрэгт зориулан төсвийн гадуур "Ахмадын тусламжийн сан" байгуулах боломжийг эрж хайж шийдвэл их буянтай үйлс болох буй заа.



**Хүндэт хилчин, чөлөөнд байгаа
хурандаа И.Бат-Орших**